



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 3 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 91

Улаанбаатар
хот

Хувьсах зардлын дундаж норматив,
аргачлал батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 40.2, 40.3, 40.5, 41.3, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 15.1, 15.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:


1. "Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн"-ийг 1 дүгээр хавсралт, "Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн"-ийг 2 дугаар хавсралт, "Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр"-ийг 3 дугаар хавсралт, "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар тооцсон зардлыг энэ тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тооцож санхүүжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга, нийслэл, дүүргийн Боловсролын газар, хэлтсийн дарга нарт тус тус даалгасугай.

3. Боловсролын байгууллагад 2022 онд хуваарилах нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар тооцсон зардлын санхүүжилт нь 2021 оны гүйцэтгэлээс буурахаар бол төсвийг өмнөх оны түвшинд нь тооцож санхүүжүүлэх, 2022-2023 оны хичээлийн жилд холбогдох судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн сургалтын байгууллагын бүтэц, хэв шинжийг оновчтой хэлбэрээр шинэчлэн тогтоож, бүлэг дүүргэлтийг холбогдох нормын дагуу зохион байгуулах, төсвийн гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, тайлагнах, хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Боловсролын сургалтын байгууллагын хэрэгцээ шаардлагад үнэлгээ хийж эрэмбэ тогтоосны үндсэн дээр 2022 оны төсвийн жилд төрийн болон орон нутгийн өмчийн 100-аас доошгүй ерөнхий боловсролын сургуульд, цаашид бусад төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд компьютер болон шаардлагатай лабораторийн бусад тоног төхөөрөмж худалдан авахад зориулан үе шаттайгаар нөхөн хангалтын зардал хуваарилж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай" Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 242 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Боловсрол, шинжлэх ухааны сайд

Л.ЭНХ-АМГАЛАН

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХЭД НЭГ
СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ
НОРМАТИВ, ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН

(жилийн дүнгээр, мянган төгрөгөөр)

№	Бүрэлдэхүүн	Хэмжээ	Санхүүжүүлэх эх үүсвэр
A	Суурь хувьсах зардал	810	-
1	Багшийн үндсэн цалин, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Нийт хувьсах зардлын 58.5 хувь	Улсын төсөв
2	Багшийн нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Нийт хувьсах зардлын 16.8 хувь	Улсын төсөв
3	Сургалтын үйл ажиллагааны зардал	Нийт хувьсах зардлын 1.2 хувь	Улсын төсөв
B	Бусад хувьсах зардал	210	-
1	Захиргаа, аж ахуйн ажилтны орон тооны жишиг нормативаар тооцсон үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Нийт хувьсах зардлын 19.6 хувь	Үүсгэн байгуулагчийн төсөв
2	Цэцэрлэгийн үйл ажиллагааны урсгал зардал	Нийт хувьсах зардлын 1.8 хувь	Үүсгэн байгуулагчийн төсөв
3	Багшийн хөгжлийн зардал	Нийт хувьсах зардлын 0.6 хувь	Улсын төсөв
4	Эрүүл мэндийн үйлчилгээний зардал	Нийт хувьсах зардлын 0.6 хувь	Үүсгэн байгуулагчийн төсөв
5	Цахим хэрэглээний зардал	Нийт хувьсах зардлын 0.4 хувь	Үүсгэн байгуулагчийн төсөв
B	Нөхөн хангалтын хувьсах зардал*	-	-
1	Хүүхдийн тоглоом, тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал	Нийт хувьсах зардлын 0.5 хувь	Үүсгэн байгуулагчийн төсөв
Г	Нийт хувьсах зардал	100 хувь	
1	Төрөөс хариуцах зардлын хувь хэмжээ	77.1 хувь	

2	Үүсгэн байгуулагчийн хариуцах зардлын хувь хэмжээ	22.9 хувь
---	---	-----------

*нөхөн хангалтын хувьсах зардлыг 2022 оны төсвийн жилд үнэлгээнд үндэслэн сонгосон зарим цэцэрлэгүүдэд хэрэгжүүлж, цаашид үе шаттайгаар бусад цэцэрлэгүүдийг хамруулна.

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХэд НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ
ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ, ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН**

А. Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн

(жилийн дүнгээр, мянган төгрөгөөр)

№	Бүрэлдэхүүн	Хэмжээ			Санхүүжүүлэх үүсвэр
		Бага	Дунд	Ахлах	
А	Суурь хувьсах зардал	771	805	771	
1	Багшийн үндсэн цалин, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	нийт хувьсах зардлын 58.4 хувь			Улсын төсөв
2	Багшийн нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	нийт хувьсах зардлын 21.5 хувь			Улсын төсөв
3	Сургалтын үйл ажиллагааны зардал	нийт хувьсах зардлын 1.5 хувь			Улсын төсөв
Б	Бусад хувьсах зардал	139	145	139	
1	Захиргаа, аж ахуйн ажилтны орон тооны жишиг нормативаар тооцсон үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	нийт хувьсах зардлын 11.3 хувь			Үүсгэн байгуулагчийн төсөв
2	Сургуулийн үйл ажиллагааны урсгал зардал	нийт хувьсах зардлын 0.5 хувь			Үүсгэн байгуулагчийн төсөв
3	Багшийн хөгжлийн зардал	нийт хувьсах зардлын 0.9 хүртэлх хувь			Улсын төсөв
4	Эрүүл мэндийн үйлчилгээний зардал	нийт хувьсах зардлын 0.4 хувь			Үүсгэн байгуулагчийн төсөв
5	Цахим хэрэглээний зардал	нийт хувьсах зардлын 1.0 хувь			Үүсгэн байгуулагчийн төсөв
6	Анги танхимын ариутгал, цэвэрлэгээний зардал	нийт хувьсах зардлын 0.4 хувь			Үүсгэн байгуулагчийн төсөв

7	Танхимаас гадуурх сургалтын үйл ажиллагааны зардал	нийт хувьсах зардлын 0.2 хувь	Үүсгэн байгуулагчийн төсөв
В	Нөхөн хангалтын хувьсах зардал*	-	-
1	Тоног, төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал	нийт хувьсах зардлын 4-15 хүртэл хувь	Үүсгэн байгуулагчийн төсөв
Г	Нийт хувьсах зардал	100 хувь	
1	Төрөөс хариуцах зардлын хувь хэмжээ	82.2 хувь	
2	Үүсгэн байгуулагчийн хариуцах зардлын хувь хэмжээ	17.8 хувь	

*нөхөн хангалтын хувьсах зардлыг 2022 оны төсвийн жилд үнэлгээнд үндэслэн сонгосон зарим сургуулиудад туршилтаар хэрэгжүүлж, цаашид үе шаттайгаар бусад сургуулийг хамруулна.

Б. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн

(жилийн дүнгээр, мянган төгрөгөөр)

№	Бүрэлдэхүүн (Дотуур байрны хэв шинжээр)	Хэмжээ	Санхүүжүүлэх эх үүсвэр
А	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив	355.0	Үүсгэн байгуулагчийн төсөв
1	Дотуур байрны багшийн цалингийн сан, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Нийт хувьсах зардлын 90 хувь	
2	Дотуур байрны үйл ажиллагааны зардал	Нийт хувьсах зардлын 10 хувь	

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр
тогтоолын 3 дугаар хавсралт

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ
ХУВЬСАХ ЗАРДЛЫН БАЙРШИЛ, ХЭВ ШИНЖ, ХҮҮХДИЙН
ТООНООС ХАМААРСАН ӨСӨН НЭМЭГДЭХ ИТГЭЛЦҮҮР**

А. Байршлаас хамаарсан итгэлцүүр

№	Хэв шинж	Нийслэл	Аймаг	Сум
1	Цэцэрлэг	-	1.065	1.08
2	Ерөнхий боловсролын сургууль	-	1.065	1.08

Б. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн тооны итгэлцүүр

№	Суралцагчийн тоон интервал	Үржүүлэгч итгэлцүүр
1	201-350	1.68
2	351-450	1.63
3	451-550	1.58
4	551-650	1.43
5	651-800	1.37
6	801-950	1.33
7	951-1500	1.22
8	1501-2500	1.09
9	2500-аас дээш	1.00

В. Ерөнхий боловсролын сургуулийн хэв шинжийн итгэлцүүр

№	Хэв шинж	Индекс
1	Тусгай	1.75

Г. Цэцэрлэгийн хүүхдийн тооны итгэлцүүр

№	Хүүхдийн тоо	Индекс
1	1-25	2.50
2	50-75	1.75
3	76-125	1.48
4	126-175	1.42
5	176-225	1.41
6	226-275	1.31
7	276-375	1.25
8	376-450	1.22

9	451-550	1.15
10	551-650	1.05
11	651-ээс дээш	1.00

Д. Цэцэрлэгийн хэв шинжийн итгэлцүүр

№	Хэв шинж	Индекс
1	Ердийн	-
2	Тусгай	1.30
3	24 цагийн	1.30

Е. Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн жилийн нийт сургалтын төлбөрөөс хамаарсан итгэлцүүр

№	Сургалтын төлбөрийн хэмжээ	Индекс
1	Төлбөргүй болон 1,000,000.0 төгрөг хүртэл төлбөртэй	1.0
2	1,000,001.0-5,000,000.0 төгрөг хүртэл төлбөртэй	0.6
3	5,000,001.0-10,000,000.0 төгрөг хүртэл төлбөртэй	0.5
4	10,000,001.0-ээс дээш төгрөгийн төлбөртэй	0.0

Ё. Төрийн бус өмчийн цэцэрлэгийн байршлаас хамаарсан итгэлцүүр

№	Байгууллага	Нийслэл	Аймаг	Сум
1	Цэцэрлэг	1.0	1.05	1.24

ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВААР ТӨСӨВ ХУВААРИЛАХ, САНХҮҮЖҮҮЛЭХ АРГАЧЛАЛ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж норматив ашиглан боловсролын байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлыг тооцож хуваарилах, санхүүжүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаанд энэ аргачлалыг мөрдөнө.

1.2.Орон нутгийн өмчийн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх бөгөөд эдгээр зардал нь хувьсах зардлын бүрэлдэхүүнд тооцогдохгүй.

1.3.Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт улсын төсвөөс хувьсах зардлын дундаж нормативаар тооцсон зардлын санхүүжилт олгох үндэслэл нь байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, сургалтын үйл ажиллагааны хамрах хүрээ, тогтвортой байдал, үр дүнг илэрхийлсэн албан ёсны статистик, төсвийн төсөлд өгсөн санал байна.

Хоёр.Нэр томъёо

2.1.Энэ аргачлалд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1.“хувьсах зардлын дундаж норматив” гэж цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, стандартыг хангахад зайлшгүй шаардлагатай, суралцагч хүүхдийн тооноос шууд хамааралтайгаар өөрчлөгдөх нийт зардлын нэг суралцагчид ногдох дундаж хэмжээг;

2.1.2.“цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль” гэж Боловсролын тухай хуулийн 14.1-д заасныг;

2.1.3.“хүүхэд өдөр” гэж тодорхой хугацааны доторх хуанлийн нийт ажлын өдөр ба хамрагдах суралцагчийн тооны үржвэрийг;

2.1.4.“төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлбөр” гэж эрх бүхий байгууллага, албан тушаалтан болон зөвлөл, хурлын шийдвэрээр баталгаажсан, аливаа хөнгөлөлт, чөлөөлөлт тооцоогүй бүтэн жилийн сургалтын төлбөрийн хэмжээг;

2.1.5."судлагдахууны бүлэглэл" гэж шаардлагатай багшийн сургалтын цагийг тооцохдоо сургуулийн хэмжээнд нэгтгэж бодох боломжит хэд хэдэн хичээлийн нэгдлийг;

2.1.6."шаардлагатай багшийн тоо" гэж боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу тухайн сургуульд хичээл заах, хүний нөөцийн болон цалин хөлсний системд бүртгэгдэх, төсвийн жилийн цалингийн санг тооцох нийт багшийн тоог;

2.1.7."сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт" гэж сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэвийн нөхцөлийг хангах, сургалтын биет орчны батлагдсан стандартад үе шаттай нийцүүлэхэд зайлшгүй шаардлагатай (суурин болон зөөврийн компьютер, цахим хэрэглэгдэхүүн, байгалийн ухааны лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, биет үзүүлэн болон сургалтын хэрэглэгдэхүүн г.м) зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах дундаж хугацаа, анхны худалдан авалтын өртгийг харгалзан нэг хүүхдэд тухайн жилд ногдох өртөг буюу элэгдлийн зардлыг харгалзан дундаж нормативт зардлаар санхүүжүүлж буй сургалтын тоног төхөөрөмж худалдан авах, эзэмших, ашиглах үйл ажиллагааг.

Гурав.Хувьсах зардлын дундаж норматив

3.1.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хувьсах зардлын дундаж нормативт үндэслэн олгох санхүүжилт нь сургалтын байгууллага батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх захиргаа, удирдлагын болон мэргэжлийн чадварлаг багшлах хүний нөөцөөр хангагдах, сургалтын тоног төхөөрөмж, хичээл, практикийн үйл ажиллагааг хэвийн явуулах, боловсролын стандартыг хангахад чиглэсэн зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааны урсгал зардалд хүрэлцэхүйц байна.

3.2.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хувьсах зардлын дундаж норматив нь дараахь төрөлтэй байна:

3.2.1.суурь хувьсах зардал;

3.2.2.бусад хувьсах зардал.

3.3.Суурь хувьсах зардлын санхүүжилтийг өмчийн хэлбэр харгалзахгүй олгох бөгөөд дараахь бүрэлдэхүүнтэй байна.

3.3.1.багшийн цалин хөлс, түүнд хууль тогтоомжид заасны дагуу ногдох нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардал;

3.3.2.сургалтын хөтөлбөрийн дагуу хэрэглэгдэх сургалтын хэрэглэгдэхүүн, материал, хангамж буюу хичээл сургалтын үйл ажиллагааны зардал.

3.4.Бусад суурь хувьсах зардал нь дараахь бүрэлдэхүүнтэй байх бөгөөд төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн санхүүжилтийг үүсгэн байгуулагч,

төрийн болон орон нутгийн өмчит сургууль, цэцэрлэгийн санхүүжилтийг төр хариуцна:

3.4.1.багш бус ажилтны цалин хөлс, түүнд хууль тогтоомжид заасны дагуу ногдох нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардал;

3.4.2.сургалтын байгууллагын анги, танхимын эрүүл ахуйн шаардлагыг хангах ариутгал, цэвэрлэгээний болон үйл ажиллагааны зардал;

3.4.3.багшийн тасралтгүй хөгжлийг хангахад чиглэсэн сургалтын зардал;

3.4.4.хууль тогтоомжийн дагуу багш болон бусад албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, мэргэжлээс шалтгаалах өвчний онцлогийг харгалзан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулахтай холбоотой зарим зардал;

3.4.5.хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон цахим хосолсон, эсвэл зайн хэлбэрээр зохион байгуулахад шаардлагатай хөдөлгөөнт интернетийн үйлчилгээ, сургалтын удирдлагын мэдээллийн систем, цахим контентын хэрэглээ, программ хангамжийн ашиглалтын зардал;

3.4.6.сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулахад багшид шаардлагатай хичээл, практик, лаборатори, кабинетын сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалтад ороогүй бичгийн цаас, шохой, бал, маркер, принтерийн хор, судлагдахууны онцлогтой хэрэглэгдэх туршилт, дадлагын химийн урвалж бодис, технологийн хичээлийн бэлдэц, мод, материал, сагсан бөмбөг, хөл бөмбөг зэрэг бага үнэтэй, түргэн элэгдэх хангамжийн материал, хэрэгслийн зардал;

3.4.7.ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын танхимаас гадуурх хичээл, сургалтын үйл ажиллагаанд шаардагдах зарим зардал;

3.4.8.сургалтад ашиглагдах суурин болон зөөврийн компьютер, цахим хэрэглэгдэхүүн, лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хэрэглэгдэхүүн (сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хувьд сургалтын хөтөлбөрийн хүрээнд ашиглагдах хүүхдийн тоглоом, хэрэглэгдэхүүн)-ий ашиглалт, нөхөн хангалтын зардал.

3.5.Суурь болон бусад хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй зааврыг энэ аргачлалын хавсралтад заасны дагуу мөрдөнө.

3.6.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг инфляц, улсын дундаж цалин хэлс болон эдийн засгийн өсөлтийн сүүлийн 3 жилийн дунджийг тус тус харгалзан шинэчлэх санал боловсруулан, Засгийн газрын шийдвэрээр жил бүр тогтоолгож, шаардагдах зардал, санхүүжилтийг дараа оны төсвийн төсөлд тусган батлуулна.

3.7.Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүнээс энэ аргачлалын 3.4.8-д заасан зориулалт, бүрэлдэхүүнд ногдох санхүүжилтийг 2022 онд туршилтаар сонгогдсон сургууль, цэцэрлэгүүдэд олгож эхлэх бөгөөд 2023 оны төсвийн жилээс үе шаттайгаар бусад сургалтын байгууллагад олгоно.

Дөрөв.Хувьсах зардлын дундаж нормативт тохируулга хийх

4.1.Сургалтын хөтөлбөрийн болон сургалт явуулж байгаа арга хэлбэрийн онцлог, ялгаатай байдлыг харгалзан хувьсах зардлын дундаж нормативт дор дурдсан тохируулга хийж төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл түүний эрх олгосноор төсвийн төвлөрүүлэн захирагч хуваарилалт хийнэ:

4.1.1.төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургалтын байгууллагын байршил, хэв шинж, сургалтын хөтөлбөрийн онцлогийг харгалзан тухайн сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативт Засгийн газраас баталсан итгэлцүүрийг үндэслэн тохируулга хийнэ;

4.1.2.Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын албан сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 1 хувиар нэмэгдүүлж тооцно;

4.1.3.цэцэрлэгийн хувилбарт сургалтын нүүдлийн бүлэгт хамрагдах нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативын 30 хувийг, явуулын багшийн сургалтад хамрагдах нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативын 10 хувийг тус тус олгоно;

4.1.4.өмчийн бүх хэлбэрийн ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагч, хүүхдэд ногдох хувьсах зардлыг гурав дахин нэмэгдүүлж тооцно;

4.1.5.төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг 14 хувиар нэмэгдүүлж тооцно.

4.2.Үндэсний хэмжээнд нийтлэг мөрдөгдөж байгаа сургалтын стандарт хөтөлбөрөөс ялгаатай хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа боловсролын байгууллагад шаардлагатай нэмэлт зардлыг хөтөлбөр, арга хэмжээний бодит өртөг, хэрэгжих хугацаанд үндэслэн тухайн сургалтын байгууллагын төсөвт нэмж хуваарилна.

4.3.Ахлах ангийн сонголттой хичээлийн цахим сургууль (виртуал)-д суралцсан нэг сурагчийн зардлыг хувьсах зардлын нэг судлагдахуунд ногдох өртгөөр тооцно.

4.4.Ерөнхий боловсролын сургуулиудад бүлэг дүүргэлтийн батлагдсан стандарт, нормативын дээд хязгаараас хэтэрсэн ачаалалтай ажиллаж байгаа бага ангийн багшид нэмэгдэл хөлс олгож болно. Уг нэмэгдлийг хөдөлмөрийн тухай хуулийн 109.6-д заасныг үндэслэн сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна.

4.5.Энэ аргачлалын 4.4-т заасан нэмэгдэл хөлс олгох хэмжээг тогтоохдоо Багшийн хөгжлийн тухай хуулийн 8.4-т заасан хязгаар хүртэлх суралцагчийн тооноос хэтрүүлэхгүй байх, нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативын 0.1 хүртэлх хувьтай дүйцэх хэмжээнд тооцож нэмэгдүүлнэ.

4.6.Сургалтын байгууллагын дундаж бүлэг дүүргэлт нь 45 ба түүнээс дээш байх тохиолдолд сургалтын чанарыг бууруулахгүй байх, нэг багшид ногдох ачааллыг бууруулах зорилгоор хэтэрсэн ачаалалтай хэсэгт нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж хэмжээний 70-90 хүртэл хувиар бууруулж сургалтын байгууллагад санхүүжилтийг олгож болно. Цалингийн сангийн хэмжээ нь тооцсон цалингаас 30 болон түүнээс дээш хувиар хэтэрсэн тохиолдолд төсвийн захирагч тухайн байгууллагын цалингийн санг бодит цалингаар нь тооцон зохицуулалт хийнэ.

4.7.Тохируулга хийсэн зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл түүний эрх олгосноор төсвийн төвлөрүүлэн захирагч хуваарилна.

Тав.Суралцагчийн тоо

5.1.Төсвийн жилд хамрагдах суралцагчийн тоо нь дуусах хичээлийн жилд хамрагдах 6 сар болон ирэх хичээлийн жилд хамрагдах 4 сард суралцах хүүхдийн тооны нийлбэрийг хичээлийн жилийн нийт үргэлжлэх хугацаанд хуваасантай тэнцүү байна.

5.2.Төсвийн жилд суралцагчийн тоог ерөнхий боловсролын сургуулийн хувьд бага, дунд, ахлах ангид хамрагдах хүүхдийн тоогоор, цэцэрлэг болон дотуур байрны хувьд тухайн хугацаанд хамрагдаж байгаа нийт хүүхдээр тооцно.

Зургаа.Багшийн орон тоо

6.1.Ерөнхий боловсролын сургуульд шаардлагатай багшийн орон тоог тухайн хичээлийн жилийн суралцагчийн тоо, тооцсон бүлгийн тоо (бүлэг дүүргэлтийн норм болон зөвшөөрөгдөх интервалыг харгалзах бөгөөд бага 20, дунд 20-35, ахлах 20-40 хооронд г.м), хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөөг үндэслэн тодорхойлно.

6.2.Багшийн долоо хоногийн танхимаар заах хичээлийн цагийн норм нь эрх бүхий байгууллагаас баталсан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоосон болон багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журамд зааснаар тодорхойлогдоно.

6.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан сургалтын төлөвлөгөө, Засгийн газраас тогтоосон сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын норм, нормативыг үндэслэн тухайн хичээлийн жилд ажиллах боломжит багшийн орон тоог батлагдсан төсөвт багтаан тухайн сургалтын байгууллагын захирал, эрхлэгч тогтооно.

6.4.Сургуулийн бага ангийн бүлэгт нэг багш, цэцэрлэгийн ердийн бүлэгт нэг багш болон нэг туслах багш, 24 цагийн болон тусгай бүлэгт 2 туслах багш ажиллахаар тус тус тооцно.

6.5.Хичээлийн долоо хоногийн нийт цагийг судлагдахууны бүлэглэл бүрээр тодорхойлох бөгөөд бага ангийн багшийн сургалтын цагт бэлтгэл хөтөлбөр, монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, математик, иргэний ёс зүйн боловсрол, хүн нийгэм, хүн байгаль, зураг зүйн хичээлийн төлөвлөгөөт цагаас бүрдэнэ. Дунд, ахлах ангийн багшийн сургалтын цагийг нийт дүнгээр тооцох бөгөөд бага ангийн биеийн тамир, хөгжим, англи хэлний хичээлийн цагийг нэмнэ.

6.6.Сургуулийн сургалтын цагийг долоо хоногийн багшийн цагийн нормд харьцуулан шаардлагатай багшийн тоог судлагдахууны бүлэглэл бүрээр тооцно.

6.7.Багшийн нийт сургалтын цагийг тооцохдоо дараахь байдлаар судлагдахууныг бүлэглэнэ:

Судлагдахууны бүлэглэл	Хамаарах анги
Монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол	6, 7, 8, 9, 10, 11, 12
Казак хэл, казак уран зохиол	6, 7, 8, 9, 10, 11, 12
Математик	6, 7, 8, 9, 10, 11, 12
Мэдээллийн технологи*	6, 7, 8, 9, 10, 11, 12
Физик	6, 7, 8, 9, 10, 11
Биологи, Эрүүл мэнд	6, 7, 8, 9, 10, 11
Хими	6, 7, 8, 9, 10, 11
Нийгэм, Иргэний ёс зүйн боловсрол, Түүх	6, 7, 8, 9, 10, 11, 12
Газар зүй	7, 8, 9, 10, 11
Англи хэл*	5, 6, 7, 8, 9, 10, 11, 12
Орос хэл*	7, 8, 9
Биеийн тамир	1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12
Хөгжим	6, 7, 8, 9
Зураг зүй, технологи*	6, 7, 8, 9, 10, 11, 12
Сонгох хичээл	10, 11, 12

*Дэд бүлгээр хичээллэхээр тооцож болно.

6.8.Шаардлагатай багшийн тоог бага, дунд, ахлах ангиар тус бүр тооцож нэгтгэн доорх томъёогоор тооцон гаргана:

$$CS_a = \left(\left(\frac{CH_a^g}{TW^g} \right) * TN^g \right)$$

CS_a = а судлагдахуун бүлэглэлийн нийт шаардлагатай багшийн тоо

$$CH_a^g =$$

а судлагдахууны бүлгийн g ангийн албан ёсны сургалтын судлагдахуун төлөвлөгөөний дагуу жилийн нийт хичээллэх цагийн тоо

TW^g = g хамаарах ангийн хичээлийн жилийн хичээллэх долоо хоногийн тоо

TN^g = g хамаарах ангийн нийт бүлгийн тоо

$$TCS_i = TCS_{(i-1,i)} + \Delta TCS_{(i,i+1)}$$

TCS_i = i онд шаардлагатай нийт багшийн тоо

$TCS_{(i-1,i)}$ буюу тухайн оны эхний хичээлийн жилийн хичээлийн хөтөлбөр, бүлгийн тооноос хамаарсан шаардлагатай багшийн тоо

$TCS_{(i,i+1)}$ буюу тухайн оны сүүлийн хичээлийн жилийн бүлгийн тооны өөрчлөлтийг тооцсон шаардлагатай багшийн тооны өөрчлөлт

Долоо.Зардал төлөвлөх, хуваарилах

7.1.Төсвийн шууд захирагч нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар тооцож төсвийн төслөө боловсруулан аймгийн боловсрол, шинжлэх ухааны газарт нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэст хүргүүлэх бөгөөд аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс нь саналыг хянан, нэгтгэж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлнэ.

7.2.Төсвийн ерөнхийлөн захирагч нь хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг энэ аргачлалын 3.5-д заасны дагуу шинэчлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасан төсвийн цаглабарт нийцүүлэн шийдвэрлүүлэх, улсын хэмжээнд нэгтгэсэн төсвийн саналыг эцэслэн батлуулах ажлыг зохион байгуулна.

7.3.Төсвийн ерөнхийлөн захирагч, эсвэл түүний эрх олгосноор төсвийн төвлөрүүлэн захирагч нь батлагдсан төсвийг бодит тоо, мэдээлэлд үндэслэн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативаар тооцоолж цэцэрлэг, сургууль тус бүрээр хуваарилж, батлуулна.

7.4.Хувьсах зардлын санхүүжилтийг аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс нь хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь тооцож, батлагдсан хуваарьт нийцүүлэн сар бүр сургалтын байгууллагад олгоно.

7.5.Нэг хүүхдэд ногдох зардлын дундаж нормативаар олгох санхүүжилтийн гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж хагас, бүтэн жилээр тооцон, зохих өөрчлөлтийг тусган төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн шийдвэрээр санхүүжүүлж болно.

7.6.Улсын хэмжээнд болон тухайн орон нутагт өндөржүүлсэн бэлэн байдал, бүх нийтийн бэлэн байдал, онцгой нөхцөл байдал тогтоосон үед боловсролын байгууллагын танхимын сургалтыг онлайн, теле болон цахим хэлбэрт шилжүүлсэн тохиолдолд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг тухайн хичээлийн жилийн албан ёсны статистик мэдээлэлд үндэслэн хуваарилна.

7.7.Төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгт хуваарилах сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг хуваарилах, гүйцэтгэлийг хангуулахад дараахь үйл ажиллагааг зохион байгуулна:

7.7.1.сургалтын байгууллага нь шаардлагатай тоног төхөөрөмжийн хэрэгцээний судалгааг сургалтын байгууллагын түвшинд гаргах;

7.7.2.төсвийн ерөнхийлөн захирагч эсхүл түүний эрх олгосноор төсвийн төвлөрүүлэн захирагч нь боловсролын систем дэх сургалтын хэрэглэгдэхүүний өнөөгийн төлөв байдлын судалгаа болон бусад нэмэлт судалгааны үр дүнг харгалзан шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт, техникийн тодорхойлолтыг боловсруулж, батлах;

7.7.3.төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургуулиудад тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг хуваарилахад хүүхэд бүрт суралцах ижил боломжийг бүрдүүлэх зорилгоор тоон болон чанарын үзүүлэлт, хүртээмжийн шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үнэлгээ хийсний үндсэн дээр хамрагдах сургуулиудыг тогтоох;

7.7.4.энэ аргачлалын 7.7.3-т заасны хүрээнд төсвийн шууд захирагч нь тухайн сургалтын байгууллагад хуваарилагдах тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлаар шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах хэрэгцээг эрэмбэлж, үе шаттай шийдвэрлэх төлөвлөгөө баталж, шийдвэрлэх;

7.7.5.сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлага нь энэ аргачлалын 7.7.4-д тодорхойлсон санал, шийдвэрийн тослийг өөрийн удирдлага буюу эцэг, эхийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тус зөвлөлийн санал, дүгнэлтээр дэмжигдсэн жагсаалтыг баталснаар худалдан авах ажиллагааг явуулах;

7.7.6.эрх бүхий байгууллагын холбогдох шийдвэрийн дагуу нөхөн хангалтын хүрээнд шаардлагатай сургалтын тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран ерөнхий гэрээний аргаар хийх;

7.7.7.төсвийн шууд захирагч нь ерөнхий гэрээ байгуулсан гүйцэтгэгч байгууллагаас холбогдох журмын дагуу худалдан авах ажиллагааг бие даан явуулах;

7.7.8. сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын үйл ажиллагааг сургалтын байгууллагын өөрийн удирдлага, багш ажилтны оролцоог хангаж, ил тод зохион байгуулж, тайлагнах.

7.8. Энэ аргачлалын 7.7 нь төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэг болон төрийн өмчийн шинээр ашиглалтад орох сургууль, цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмжийн хангалт, нөхөн хангалтад хамаарахгүй.

7.9. Давагдашгүй хүчин зүйл үүссэн, төсвийн захирагч нарын үйл ажиллагаа тогтворжоогүй байгаа нөхцөлд төсвийн ерөнхийлөн захирагч улсын хэмжээнд нийт төсвийн хуваарилалтыг сар бүрээр, байгууллагын нийт дүнгээр баталж мөрдүүлж болно.

Найм.Хувьсах зардлын дундаж нормативаар тооцож санхүүжилт олгох

8.1. Сургалтын нэг хүүхдэд ногдох дундаж нормативт зардлын санхүүжилтийг аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу сар тутам олгоно.

8.2. Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургалтын байгууллагын удирдлага нь хувьсах зардлын дундаж нормативаар тооцон хуваарилсан санхүүжилтийг зарцуулахдаа дараахь зарчим, чиглэлийг баримтална:

8.2.1. хичээл, сургалтын үйл ажиллагаа хэвийн, тасралтгүй явагдах нөхцөлийг хангах;

8.2.2. сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эрх бүхий байгууллагаас баталсан орон тооны хязгаар болон зардлын норм, нормативыг чанд мөрдөх;

8.2.3. хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай багшийн орон тоог тухайн хичээлийн жилийн суралцагчдын тоо, тооцсон бүлэг (бага, дунд, ахлах)-ийн тоонд үндэслэн бүлэг дүүргэлтийн нормын дагуу тооцож хамгийн бага байхаар сургалтын төлөвлөгөөг оновчтой баталж, мөрдүүлэх;

8.2.4. багшийн цалин хөлс, урамшууллыг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн гүйцэтгэл, үр дүнг нь харгалзан тухайн сургалтын байгууллагын баталсан жилийн төсөвтөө багтаан тогтоож, олгох;

8.2.5. багшийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийн нөхөн хангалт хийх, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, шийдвэр гаргахад сургууль, цэцэрлэгийн зөвлөлд танилцуулж, зөвлөлийн саналаар хамгийн өндөр эрэмбэлэгдсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;

8.2.6. сургалтын байгууллагын төсөв хуваарилах, хэрэгжүүлэхэд ил тод байдлыг хангах, эцэг, эхийн зөвлөл, олон нийтийн оролцоог хангах.

8.3.Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, бусад ажилтны цалин хөлсийг тогтоож олгоход дараахь зохицуулалтыг мөрдлөг болгоно:

8.3.1.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цалингийн санд багш, бусад ажилтны үндсэн цалин, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, анги даасан, кабинет, лаборатори хариуцан ажилласан, заах аргын нэгдэл удирдсаны нэмэгдэл, мэргэшлийн зэргийн нэмэгдэл, тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдэд хичээл заасны нэмэгдэл, орон нутгийн нэмэгдэл, Засгийн газрын тогтоолоор баталсан бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлс, тэдгээрт ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл тус тус багтана;

8.3.2.цалингийн санг тооцохдоо эрх бүхий байгууллагаас баталсан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны багшаас бусад ажилтны орон тооны жишиг нормативын дагуу тооцсон албан хаагчдын үндсэн цалин, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, орон нутгийн нэмэгдэл болон гүйцэтгэлийн урамшууллаас бусад Засгийн газрын тогтоолоор баталсан бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлс, тэдгээрт ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл тус тус багтана;

8.3.3.шаардлагатай багшийн орон тоог энэ аргачлалын "зургаа"-д заасны дагуу тооцсон байна;

8.3.4.ерөнхий боловсролын сургалтын байгууллагын дэд бүтцийн хүчин чадлын ашиглалт хэт өндөр, бүлэг дүүргэлтийн батлагдсан стандартын дээд хязгаараас хэтэрсэн ачаалалтай ажиллаж байгаа бага ангийн багшид стандартаас илүү хүүхэдтэй ажилласан нэмэгдэл хөлс олгож болно.

8.4.Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативт үндэслэн олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах үүрэгтэй.

8.5.Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар олгосон санхүүжилтийн жилийн эцсийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн сургалтын байгууллагын хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх, багшийн хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах зориулалтаар сургууль бие даан зохих хууль тогтоомжийн хүрээнд зарцуулж болно.

8.6.Энэ аргачлалын 8.5-д заасан шийдвэрийг сургалтын байгууллагын өөрийн удирдлага, хамт олны 2/3-оос доошгүй ирцтэй хурлын шийдвэрийг үндэслэн тухайн сургалтын байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ.

8.7.Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ.

Ес.Төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд
хувьсах зардлын дундаж нормативаар
тооцож зардал хуваарилах

9.1.Төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардалд төрөөс олгох санхүүжилтийн хэмжээг тухайн жилийн төсвийн төсөлтэй хамт ирүүлсэн сургалтын төлбөр тогтоосон шийдвэр,

Засгийн газраас баталсан сургалтын төлбөрөөс хамаарах итгэлцүүрийг баримтлан тооцно.

9.2.Сургалтын байгууллага нь төсвийн төслийн саналыг энэхүү аргачлалд нийцүүлэн жилээр төлөвлөж, аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэст төсвийн цаглабарт заасан хугацаанд хүргүүлнэ.

9.3.Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн байгууллагын гэрчилгээ, сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл, сургалтын төлбөр тогтоосон албан ёсны шийдвэрийн хуулбар нь төсвийн төслийн салшгүй хэсэг байна.

9.4.Тухайн цэцэрлэг, сургуулийн төсвийг хичээлийн жилийн боловсролын албан ёсны статистик мэдээний хүүхдийн тоо, сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хавсралтаар баталсан хүүхдийн тоонд үндэслэн хянана.

9.5.Санхүүжилт хийх дундаж хүүхдийн тоо нь тухайн хичээлийн жилийн албан ёсны статистикийн мэдээлэл дэх хүүхдийн тоо болон сургалт эрхлэх тусгай зөвшөөрлөөр баталсан хүүхдийн тооноос ихгүй байна.

9.6.Санхүүжилтийг хүүхэд өдрийн гүйцэтгэлээр тооцож, аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу сар бүр/улирал тутам олгоно.

Арав.Төсвийн гүйцэтгэл, төлбөр тооцоо, тайлагналт

10.1.Боловсролын байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайланг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан гаргана.

10.2.Төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргахдаа санхүүгийн программаар боловсруулж, мөнгөн гүйлгээний тайланд тохируулга хийж бэлтгэнэ.

10.3.Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг Төсвийн тухай хууль, холбогдох эрх зүйн актын хүрээнд аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс хянаж, нэгтгэн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлнэ.

10.4.Төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг нь хөрөнгийн өөрчлөлтийг тухай бүр Боловсролын мэдээллийн нэгдсэн санд оруулж, тайлагнана.

Арван нэг.Хяналт болон бусад

11.1.Төрийн сан нь төсвийн зарцуулалтыг хөтөлбөр, зориулалт, арга хэмжээний ангиллаар хянаж, санхүүжилт олгоно.

11.2.Төсвийн ерөнхийлөн захирагчаас өгсөн чиглэл, батлагдсан төсвийн хуваарилалт, энэ аргачлалын дагуу аймаг, нийслэл, дүүргийн боловсролын


удирдлагын байгууллагууд, тэдгээрийн санхүү, төсөв, гүйцэтгэл хариуцсан нэгж, албан хаагчид төсвийн хэрэгжилт, гүйцэтгэлийн хяналтыг удирдан зохион байгуулна.

11.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс нь төрийн сангийн төлбөр тооцооны системээр дамжуулан төсвийн хуваарилалт, санхүүжилт, гүйцэтгэлд хяналт тавина.

11.4.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас боловсролын сургалтын байгууллагын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэл, тайлагналтыг цахим мэдээллийн системд үндэслэн гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн байна. Цахим систем нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд ашиглаж байгаа цахим системтэй мэдээлэл солилцох, харилцан уялдаатай ажиллах боломжтой байна.

11.5.Төрийн албаны цалингийн мэдээллийн систем дэх цалингийн гүйцэтгэлийн мэдээллийг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгон боловсролын мэдээллийн систем хөрвүүлж авах бөгөөд энэ нь салбарын орон тоо, цалингийн сангийн албан ёсны суурь мэдээлэл болно.

11.6.Төрийн сангийн төлбөр тооцооны системээс гаргасан мэдээлэлд үндэслэн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн программаар боловсруулсан боловсролын салбарын байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгож, дараагийн сарын 05-ны өдрийн дотор боловсролын мэдээллийн системд хөрвүүлсний үндсэн дээр салбарын төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэнэ.



"Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, СУРГУУЛИЙН ӨМНӨХ БАЙГУУЛЛАГЫН
НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВЫН
БҮРЭЛДЭХҮҮН, ЗАРДЛЫН ЗОРИУЛАЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
ДЭЛГЭРЭНГҮЙ ЗААВАР

№	Зориулалт, арга хэмжээ	Зардлын дэлгэрэнгүй тайлбар	Эдийн засгийн ангилал
1.	Шаардлагатай багшийн тоо, орон тооны жишиг нормативаар тооцсон захиргаа, аж ахуйн ажилтны тоонд хамаарах үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл	Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын цалингийн санд багш, ажилтны үндсэн цалин, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, заах аргын нэгдэл удирдсаны нэмэгдэл, мэргэшлийн зэргийн нэмэгдэл, тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдэд үйлчилгээ үзүүлсний нэмэгдэл, орон нутгийн нэмэгдэл, гүйцэтгэлийн урамшууллаас бусад Засгийн газрын тогтоолоор баталсан бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлс, тэдгээрт ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл тус тус багтана.	Цалин хөлс, урамшууллын зардлын бүлэгт хамаарна.
2.	Сургуулийн үйл ажиллагааны урсгал зардал	Байгууллагын хэвийн үйл ажиллагааны зардалд захиргааны бичиг хэрэг, тээвэр шатахуун, томилолт, бараа үйлчилгээний бусад, төлбөр хураамж, даатгал гэх мэт зардал багтана.	Бараа, үйлчилгээний бусад эдийн засгийн ангилал (бичиг хэрэг, тээвэр шатахуун, томилолт, төлбөр хураамж г.м)
3.	Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих зардал	Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад) үйл ажиллагааны зардал багтана.	Бараа, үйлчилгээний бусад зардал
4.	Эрүүл мэндийн үйлчилгээний зардал	Эрүүл мэндийн үйлчилгээнд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан шийдвэрийн дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арьс өнгө, сүрьеэ, цагаан	Бараа, үйлчилгээний бусад зардал

		хорхой, нян тээгч илрүүлэх үзлэг шинжилгээ, эрүүл мэндийн даатгалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулах "Багш" багцын үзлэг, шинжилгээ багтана.	
5.	Цахим хэрэглээний зардал	Цахим хэрэглээний зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай цахим систем, дата, цахим эрх зэрэг бусад мэдээлэл технологийн зардал багтана.	Бараа, үйлчилгээний бусад зардал (бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ)
6.	Анги танхимын ариутгал, цэвэрлэгээний зардал	Ариутгал, цэвэрлэгээ, сургуулийн нийтийн эзэмшлээс бусад анги танхимын үйлчилгээ, цэвэрлэгээний зардал багтана.	Бараа, үйлчилгээний бусад зардал
7.	Хичээл сургалтын үйл ажиллагааны зардал	Хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах, багшийн сургалтад шаардлагатай орчныг бий болгох зориулалттай зардал байна. Хичээл, практикийн зардалд лаборатори, кабинетын сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалтад байхгүй материал, бичгийн цаас, шохой, бал, маркер, принтерийн хор, судлагдахууны онцлогтой хэрэглэгдэх, туршилт дадлагын явцад шаардагдах химийн урвалж бодис, технологийн хичээлийн бэлдэц, мод материал, сагсан бөмбөг, хөл бөмбөг, тугалган цаас, лаа, зай, хадаас, оёдлын угас, даавуу зэрэг гэх мэт хөрөнгийн бус хангамжийн материал багтана.	Бараа, үйлчилгээний бусад зардал (хичээл, практикийн зардал)
8.	Танхимаас гадуурх хичээл сургалтын үйл ажиллагааны зардал	Танхимын бус сургалтын үйл ажиллагааны зардалд суралцагчдыг сургуулиас гадна музей, номын сан, түүхийн дурсгалт газарт түшиглэн танхимаас гадуурх сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зардал багтана.	Бараа, үйлчилгээний бусад зардал (хичээл, практикийн зардал)
9.	Сургалтын тоног, төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал	Тоног, төхөөрөмжийн нөхөн хангалтад ерөнхий боловсролын сургалтын орчин болон цахим орчныг бүрдүүлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, компьютер түүний дагалдах хэрэгслийн насжилтаас хамаарч нөхөн хангалт хийх зардал багтана.	Бараа, үйлчилгээний бусад зардал (багаж хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмж)